



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090
Утас: 7059 2494 Факс: (976) 7059 2494
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2024.06.11 № 04/786

танай _____-ны № _____-т

Захирамж хянасан тухай

Таны 2024 оны 2 дугаар улиралд батлан гаргасан нийт 36 захирамжийн эрх зүйн үндэслэлийг хянаж үзэхэд доорх зөрчлүүд илэрч байна. Үүнд:

1.“Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” А/39 дүгээр захирамжид үндэслэсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн нэрийг Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай гэж үг нэмж бичихгүй байх,


2.“Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах тухай” А/48 дугаар захирамжид үндэслэсэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 171 дүгээр тогтоолыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон тул тус тогтоолыг үндэслэхгүй байх,

3.“Орон нутгийн өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулах тухай” А/49 дүгээр захирамжид үндэслэсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн өмнө Монгол Улсын гэж авахгүй байх,

4.“Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг татан буулгах тухай” А/51 дүгээр захирамжид Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21 дахь заалтыг үндэслэх шаардлагагүй, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Журам батлах тухай” 438 дугаар тогтоол нь даатгуулагчийн тэтгэмжтэй холбоотой байх тул ямар үндэслэлээр тус тогтоолыг баримтлах шаардлагагүй.

5.“Үнэлгээний хороо байгуулах тухай” А/52, А/60 дугаар захирамжид үндэслэсэн 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль нь хүчингүй болж 2023 оны 06 сарын 16-ны өдөр тус хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийг тус тус үндэслэх,

Сумын Засаг даргын батлан гаргасан нийт 36 захирамжийн 6 буюу 16,6 хувь нь ямар нэгэн алдаатай буюу зөрчлийн шинж байдлыг агуулж байх тул тухайн шийдвэрийн төслийг боловсруулсан албан хаагчдад танилцуулж, зөрчилтэй шийдвэр дахин гаргахгүй байхад анхаарах, шинэчлэн батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомжийг тухай бүр судлан гаргасан алдаа дутагдлыг залруулж зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тус хэлтэст 5 хоногийн дотор нотломжийн хамт хариу мэдэгдэж, цаашид баталж буй шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлж ажиллана уу.



Дундговь аймгийн засаг даргын тамгын газар
Хууль, эрх зүйн хэлтэс
Хэлтсийн дарга
Лувсанням Баярсайхан
2024-06-13 12:06:20